

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07-р сарын 07-ны өдөр

№ 25/44

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дах заалт, Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмын 6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/22 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн шинээр гаргах Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт цаасыг хөрөнгө оруулагч нарт худалдан борлуулах зорилгоор Үндсэн андеррайтераар “Голомт Капитал ҮЦК” ХХК-ийг, Туслах андеррайтераар Компанийн зэргэлдээ компани болох “Инвескор Капитал ҮЦК” ХХК-ийг сонгон “Андеррайтерын үйлчилгээний гэрээ” байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, Андеррайтерын үйлчилгээний гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

